

УЛС ТӨР СУДЛАЛЫН САЛБАРТ 1990-ЭЭД ОНООС ӨМНӨ ХЭРЭГЖСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙН БАЙДЛЫН ТОЙМ*

(тэргүүн хэсэг)

О.Хатанболд, доктор (PhD)
А.Хишигдаваа, докторант
ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
Улс төр, эрх зүйн салбар

Товч утга: Манайд харьцангуй хожуу үед үүссэн шинжлэх ухааны нэг бол улс төрийн шинжлэх ухаан юм. Бид энэхүү өгүүлэлдээ 1990-ээд оноос хойш хэрэгжсэн улс төр судлалын судалгаа, шинжилгээний онол арга, зүй, шинж байдлын өнөөгийн төлөвийг судалгааны бүтээлүүдийн онол арга зүй, үзэл баримтлал, шийдвэрлэх арга замыг нэгтгэн дүгнэж тоймлох байдлаар бэлтгэв. Чингэхдээ туулж өнгөрүүлсэн замаа эргэн харж, түүнээс сургамж авч, судалгаа шинжилгээний ажлаа улам чамбайруулах нь бидний өмнөө тавьсан гол зорилтуудын нэг тул өнгөрсөн үеийг эргэн дурсахуй нь түүний мөн чанар болоод дараа дараагийн үедээ уламжлагдан үлддэг сонголт байдаг. Тэрхүү агуулгын хүрээнд бид оршил хэсэгтээ монголчуудын улс төрийн мэдлэг, сэтгэлгээний уламжлалын талаарх тоймыг цухас тэмдэглэв. Тиймээс эл тойм өгүүлэлд Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүйн төлөв байдлыг 1990 оноос өмнөх ба хойш хэмээн **хоёр үндсэн хэсэгт** хуваан дараах байдлаар үечлэн авч үзэхийг оролдов. Үүнд, (i) Монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүний мөн чанарын талаарх тойм; (ii) Шинжлэх ухааны коммунизмын онол болон марксист-ленинист сургаалын үе (1972-1990); (iii) Шинэ онол, арга зүйг эрэлхийлэхүй буюу шилжилтийн үе (1990-2000); (iv) Улс төрийн шинжлэх ухааны шинэ төлөвшилтийн үе (2000-2010); (v) Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны судалгааны өнөөгийн байдал, цаашдын хандлага (2010 оноос- өнөөг хүртэл)

Түлхүүр үг: улс төрийн шинжлэх ухаан, судалгааны тойм, онол, арга зүй, монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүхэн уламжлал, шилжилт, төлөвшилтийн үе, өнөөгийн төлөв, хандлага

Abstract: One of the relatively recent sciences in our country is political science. In this article, we have summarized the current state of political science research theory, methodology, and characteristics since the 1990s by summarizing the theories, concepts, and solutions of the research papers. One of our main goals is to look back to our history, learn from it, and refine our research, so recalling the past is its nature and a choice that will be passed on to future generations. In that context, we have outlined in our introductions an overview of Mongolian political knowledge and thought traditions. Therefore, in this review article, we have tried to divide the political science research, analysis theory

* Эл эрдэм шинжилгээний өгүүллгийг ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний 2.2-т тусгагдсан “1990-ээд оноос хойш Монголын нийгэмд гарсан хувиралт өөрчлөлтийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, тохиолдож буй бэрхшээл сорил, тулгамдаж буй асуудлуудын гарц шийдлийн зохист хувилбарыг санал болгох” ажлын хүрээнд бэлтгэн боловсруулав.

and methodological situation in Mongolia before and after 1990 into two main parts and periodically as follows. These include (i) an overview of Mongolian political thinking and its nature; (ii) The Theory of Scientific Communism and the Marxist-Leninist Doctrine (1972-1990); (iii) The search for new theories and methodologies or the transition period (1990-2000); (iv) the new development of political science (2000-2010); (v) Current status and future trends of political science research in Mongolia (2010-present)

Keywords: *Political science, research overview, theory, methodology, political thinking of Mongolians, historical traditions, transition, development period, current state and trends*

Оршил

Улс төрийн сэтгэлгээ бол монголын ард түмний нийгмийн сэтгэлгээний түүхэнд голлох байр суурь эзэлж, түүний тэргүүлэх чиглэлийн нэг болсоор ирсэн баялаг агуулгатай, үндэсний онцлог шинжтэй, оюун санааны түүхийн үнэт өв сан болох нь эдүгээ шинжлэх ухаанд нэгэнт тодорхой болсон зүйл билээ. Монголчуудын улс төрийн сэтгэлгээний түүхэн уламжлал ба өнөөдөр манай оронд орчин цагийн улс төрийн шинжлэх ухаан дэлхийн хөгжилтэй орнуудын жишиг, туршлагыг чиг баримжаа, үлгэр загвар болгож бүрэлдэн хөгжсөөр ирсэн нь уламжлал, шинэчлэлийн хэлхээ холбоотой гэж болно. Тиймээс манай оронд улс төрийн шинжлэх ухаан бүрэлдэн хөгжиж буй өнөөгийн үйл явцыг авч үзэхдээ монголын улс төрийн сэтгэлгээ, монголчуудын улс төрийн мэдлэг ухааны түүх, уламжлал зэргийг товч боловч хөндөж тоймлон өгүүлэх хэрэгтэй болно. Монголчууд төр ёсны эртний түүх, уламжлалтай ард түмэн бөгөөд түүний тусгал, илэрхийлэл болж улс төрийн мэдлэг ухаан бүрэлдэн хөгжиж ирсэн билээ. Тэр нь төр, нийгмийн-улс төрийн амьдрал, харилцааны олон янзын үзэгдэл, үйл явцыг ердийн ухамсрын түвшнээс илүү гүнзгий тусгаж, нэгтэн дүгнэсэн ойлголт үзэл санааны цогц хэлбэр, илэрхийлэл болох улс төрийн сэтгэлгээгээр илэрч хөгжиж ирсэн явдал мөн. Чингэвэл монголчуудад улс төрийн мэдлэг, сэтгэлгээ түүхийн чухам аль үед, хэдийд үүсэн бүрэлдсэн болох, түүнийг түүхийн баримтаар судлан тогтоох боломж, үндэс суурь бий эсэхийг тодруулах нь зүйтэй. Энэ талаар цухас тэмдэглэвэл дараах дүр зураг бидний өмнө илрэх буюу.

Дэлхийд улс төрийн сэтгэлгээ анх үүсэн хөгжсөн голомт, төв бүхий улс орнуудын түүхэн жишээ баримтаас үзвэл улс төрийн сэтгэлгээ үүсэн хөгжихийн тулд *нэн тэргүүнд*, иргэншил бий болсон явдал, хүмүүсийн хамтын амьдрал, нийгэм нь улс төрийн зохион байгуулалттай болж, улмаар төр ямар нэг хэлбэр, түвшинд үүсэж бий болсон байх шаардлагатай аж. Энэ нь улс төрийн сэтгэлгээнд тусч, түүний агуулгыг нөхцөлдүүлэгч улс төрийн ахуй бүрэлдэн төлөвшсөн байна гэсэн үг. *Хоёрдугаарт*, тухайн нийгмийн соёл, ухамсар, оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн оюун ухааны түвшин, сэтгэн бодох чадвар нь улс төрийн ахуйг хийсвэрлэн сэтгэж тусгах, төсөөлөн ойлгох хэмжээнд хүрсэн байх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн сэтгэлгээний субъект бий болж төлөвшсөн байх явдал мөн. *Гуравдугаарт*, улс төрийн сэтгэлгээний үүсэл хөгжилд танин мэдэхүйн хэрэгцээ шаардлагаас илүүгээр нийгмийн анги бүлгүүдийн эрх ашиг, түүнийг илэрхийлж хамгаалсан үзэл суртлын хүчин зүйлийн үүрэг, ач холбогдол илүү давамгайлах байдлаар нөлөөлдөг. Тийм учраас, улс төрийн сэтгэлгээ үүсэн хөгжихөд улс төрийн ахуйг үзэл суртлын хэлбэрээр тусган илэрхийлэх хэрэгцээ, шаардлага, тухайлбал нийгмийн анги бүлгүүдийн эрх ашиг, байр суурийн ялгаа бий болсноор түүнийг ухамсарлаж ойлгох улс төрийн өөрийн ухамсар ямар нэг байдлаар бүрэлдсэн байхыг шаарддаг. Түүхээс үзвэл чухам ийм нөхцөл байдал, бусад холбогдох хүчин зүйлс бүрэлдсэн МЭӨ IV-III

мянган жилийн үед хүн төрөлхтний соёл, иргэншил, төр, нийгмийн сэтгэлгээний анхны голомт төвүүд бий болсон эртний дорно дахин Египет, Энэтхэг, Хятад зэрэг оронд улс төрийн сэтгэлгээ анх үүсэж, улмаар цааш хөгжих болсон байна. Ийм аналогийг жишээг монголын түүхээс эрж хайвал тэр нь манай түүхч эрдэмтдийн судалгаа ёсоор МЭӨ III зуунд тохиосон ажээ. Чухам энэ үед монголын газар нутаг төдийгүй Төв Азид анхны томоохон төр улс болох Хүннү гүрэн байгуулагдан, улс төрийн ахуй, түүний үндсэн шинж тэмдэг, үзэгдэл, үйл явдлууд тэр үеийн боломжит хэлбэр хэмжээгээр бүрэлдэн явагдаж байжээ.¹ Энэ нь монголын улс төрийн сэтгэлгээний анхны, эртний үеийн үүсэл, эхлэлийг Хүннү гүрний үеэс эрж хайн судлах нэгэн чухал үндэслэл, шалтгаан болж байгаа юм. Үүний дагуу манай эрдэмтэд эртний үеийн монголын нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэгийн үүсэл, эхлэлийг голцуу энэ үетэй холбон судалсаар иржээ. Түүний үр дүнд нийгэм, улс төрийн амьдралын тухай тэр үеийн хүмүүсийн (хүннүчүүдийн) ойлголт, үзэл санааны агуулга, тойм, зураглал ерөнхий байдлаар гарсан байна.

² Тухайлбал эзэн хаан, түүний засаглалын гарал үүсэл (эзэн хаан бол тэнгэрийн хөвгүүн бөгөөд түүний эрх мэдэл, засаглал тэнгэр гаралтай гэх мэт үзэл), захирах захирагдах харилцаа, хүчирхийлэл, албадлагыг үзэх үзэл зарим талаар тодорхой болсоор³ байгааг энд цухас тэмдэглэн үзэв. Тийм учраас эртний үеийн монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн тоймыг зураглан гаргахыг оролдохдоо түүх бичлэгт одоогоор тодорхой болж ашиглагдан буй сурвалж бичиг, улс төрийн сэтгэлгээний түүхэнд шууд ба дам байдлаар холбоо хамааралтай, гэхдээ хэсэг бусаг байгаа янз бүрийн мэдээ, баримтыг анхааралтай судлах замаар тэдгээрийн утга санааны логик холбоо, нэгдлийг гаргах ерөнхий агуулга, утга санааг нь реконструкцийн аргаар бүхэлд нь сэргээн гаргаж тавихыг хичээх, цаашлаад шинэ сурвалж бичгүүд, бусад баримт сэлтийг эрж хайх нь судалгааны шинжлэх ухаанч зарчимд нийцэх одоогийн хамгийн боломжит хийгээд бодит зорилт мөн. Ер нь улс төрийн сэтгэлгээний үүсэл, хөгжил, тэр нь түүхэнд ямар нэг байдлаар тэмдэглэгдэн үлдэхэд олон янзын хүчин зүйл, нөхцөл байдал нөлөөлдөг болох нь эртний үеийн дорно дахины орнуудын улс төрийн сэтгэлгээний түүхээс ажиглагдаж байгааг судлаачид заажээ. Аль нэг улс оронд философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ анх үүсэхийн хамт тэр нь тэмдэглэгдэж хадгалагдан үлдэхэд биеийн ба оюуны хөдөлмөрийн хуваарь ялгарч гарсан, тухайн ард түмэн суурин амьдралтай, бичиг үсэгтэй, түүх соёл, сэтгэлгээгээ бичиж тэмдэглэдэг туршлагатай байх явдал нэн чухал ажээ.

Монголын улс төрийн сэтгэлгээний түүхийг холбогдох сурвалж бичиг, баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлаж, судлан гаргах боломжтой билээ. Учир нь тийм сурвалж бичиг, шууд ба дам холбогдолтой баримт материал арвин бий. Тэдгээр сурвалж бичгүүдийг манай эрдэмтэд түүх, философи, уран зохиол, хэл шинжлэл, угсаатан судлал зэрэг ухаануудын судлагдахуун, аспектын үүднээс судлан боловсруулсаар иржээ.⁴ Одоо тэдгээр эх сурвалж, бичгүүдийг монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн үүднээс шинжлэн судлах зорилт эл чиглэлийн мэргэжилтэн судлаачдын өмнө тулгамдаж буй асуудал хэвээр байсаар буй. Энд тэдгээр сурвалж бичгүүдийг

¹ *ФСЭХ, ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 10 дахь тал*

² *Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ (Эртнээс ХИУ зуун хүртэл). Уб., 1987, 240 дэх тал*

³ *Жүгдэр Ч. XV-XVIII зууны монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. Уб., 1984, 108-110 дахь тал*

⁴ *ФСЭХ, ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 11 дэх тал*

тоочих, агуулгыг нь дэлгэрэнгүй авч үзэх шаардлагагүй. Бид тэдгээрийг дараах хэсгээр ангилахыг оролдов.

«Монголын нууц товчоо», «Арван буянт номын цагаан түүх», «Алтан товч», «Эрдэнийн товч», «Болор эрх», «Хөх дэвтэр», «Шар тууж», «Асрагч нэрийн түүх»	Монголчуудын улс төрийн сэтгэлгээ, үзэл тусаж илэрхийлэгдсэн ардын аман зохиол	Данзанраважаа, Хишигбат, Гэлэгбалсан, Данзанванжил, хуульч Сандаг, Инжиннашин	
түүхийн бичиг, намтрын зохиол, тууж, товч	цадиг, магтаал, тууж, сургаалын шүтлэг, домог, зүйр цэцэн үг	Монголын улс төрийн сэтгэлгээний хөгжилд хувь нэмэр оруулсан яруу найрагч, зохиолч, сэтгэгчийн уран бүтээлүүд	МАХН-ын улс төрийн баримт бичгүүд, намын зүтгэлтнүүдийн зохиол бүтээлүүд
XIII-XVII зуун	XVIII-XIX зуун эх	XIX-XX зууны эхэн үе	XX зууны дунд, сүүд үе
XVII-XVIII зуун	XVIII-XIX зууны зааг үе	XX зууны эхэн үе	
хууль цаазын бичиг, сурвалжууд	Монголын улс төрийн зүтгэлтэн, сэтгэгчийн сургаал, улс төрийн үзэл санаа тусаж тэмдэглэгдсэн сурвалж бичгүүд	Монголын улс төрийн сэтгэлгээ туссан тогтмол хэвлэлүүд	Монголын нийгэм судлаач, эрдэмтдийн зохиол бүтээлүүд
«Их засаг», «Хутагтай цэцэн хун тайжын цааз» (1540-1586), «Алтан хааны цаазын бичиг» (1507-1582), «Халхын цааз эрхэмжийн бичиг» (1540-1586), «Монгол-ойрадын хууль», «Халх журам»	Б.Тогтохтор, М.Пүрэвжав, Г.Цэрэнсантуу, Богд Жавзандамба, Дамдинбазар, Ханддорж, Цэрэнчимэд, Намнансүрэн, Бодоо, Данзан, Сүхбаатар, Дэмчигдорж, Ж.Цэвээн	«Монголын сонин бичиг», «Монгол үгийн бодорол», «Шинэ толь», «Нийслэл хүрээний сонин бичиг» г.м	

Бид дээрх ангиллыг хийхдээ тэдгээр сурвалж бичгүүдийн зохиогдсон цаг хугацаа, төрөл зүйл, хоорондын ялгаа, онцлог, улс төрийн сэтгэлгээ болон үзэл санаа тусаж илэрхийлэгдсэн байдал, сурвалж бичгүүдийн зохиогчид нь хэн байна вэ гэдгийг харгалзан үзэв. Тухайлбал монголын төр, нийгмийн зүтгэлтэн, түүхэн бие хүмүүс, баатар, сайн эрс, нийгэм-түүхийн томоохон үйл явдлын тухай домог, хууч ярианд ард олон, энгийн хүн ардын эрх, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдлыг үзэх үзэл санаа, эрхэмлэл, чин хүслэн, мөрөөдөл нь тусгагдсан байдаг. Үнэндээ монголчуудын улс төрийн үзэл санаа, улс төрийн эрхэмлэл нь ардын зүйр цэцэн үгэнд ч тусгагдан онч мэргэн, уран цэцнээр нэгтгэн дүгнэсэн товч хураангуй байдлаар илэрхийлэгдсэн байдаг. Энэ бол өвөрмөц, хосгүй үзэгдэл бөгөөд учир нь нийгэм, төр, улс төр, эх орон, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдал, дарлал мөлжлөг, бурангуй ёсыг үзэх үзлээ тийнхүү зүйр цэцэн үгэндээ тусган илэрхийлдэг нь монголчуудын эртнээс нааш шударга ёс, тэгш байдал, ёс суртахууныг эрхэмлэн дээдэлж ирсний нэг гол илрэл гэж үзэхэд буруудахгүй болов уу. Учир нь, монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн агуулга, дэвшүүлэн тавьж, эргэцүүлэн бясалгаж, хариу тайлбар өгч ирсэн зангилаа чухал асуудлуудыг илрүүлэн гаргаж тавих ахул дараах шалтгааныг дурдах нь зүйтэй.

Нэгдүгээрт

Эртнээс эдүгээ хүртэлх үеийн монголын улс төрийн сэтгэлгээний түүх нь агуулгаараа өргөн хүрээ багтаамжтай ба улс төрийн философи, улс төрийн сургаал, онол, номлол, үзэл суртал, улс төрийн үзэл санааны хэлбэр, түвшинд илрэн гарч, оршин хөгжиж ирсэн болох нь тодорхой болж байна.

Хоёрдугаарт

Монголын улс төрийн сэтгэлгээний түүхэнд төрийн тухай асуудал хэдийгээр гол болж тавигдсаар ирсэн ч гэсэн нийгмийн амьдралын улс төрийн хүрээний бусад олон чухал үзэгдлүүд, тухайлбал, улс төрийн бодлого, засаглал, төр улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, төр улсын задрал бутрал, түүнийг даван туулах асуудал, дарангуйлал, боолчлол, дайн ба энх, хууль цааз, шударга ёс, тэгш байдлын тухай асуудлууд ч түүхэн тодорхой байдлаар тавигдаж байжээ.

Түүхийн явцад монголын улс төрийн сэтгэлгээний агуулга, түүнд хамрагдсан асуудлын цар хүрээнд ялангуяа XX зуунд өргөжин баяжиж, дээр дурдсан уламжлалт

асуудлын зэрэгцээ нийгэм, төрийн харилцаа холбоо, төр, засаглалын хэлбэр, зохион байгуулалт, үндсэн хуульт ёс, ард олны эрх, эрх чөлөө, ардчилал, шударга ёс, сайн сайхан нийгэм байгуулах, хувьсгал, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын тухай шинэ асуудлууд чухлаар тавигдсан байдаг. Энэ нь угтаа монголын нийгмийн улс төрийн амьдралын түүхийн явцад хөгжиж, улс төрийн шинэ үзэгдлүүд гарч ирсний сацуу улс төрийн сэтгэлгээ өөрөө бие даан, өөрийн дотоод логик, хэрэгцээ шаардлагаар хөгжих болсонтой шууд холбоотой. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ 1990-ээд оноос өмнө болон хойш хэрэгжсэн улс төрийн судалгаа, шинжилгээний шинж байдлын өнөөгийн төлөвийг онол, арга зүй, үзэл баримтлал, шийдвэрлэх арга зам зэргээр нэгтгэн тоймлож дүгнэхийг зорив. Чингэхдээ Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүйн төлөв байдлыг 1990 оноос өмнөх ба хойш хэмээн дараах хэсэгт үечлэн авч үзэв.



Нэг. Монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүний мөн чанарын тухайд

Монголын улс төрийн сэтгэлгээ нь анх үүсэн бий болсон үеэс эдүгээ хүртэлх урт хугацаанд тасралтгүй, бүхэл чиг шугамтай, уламжлалын хэлхээ холбоотой байсны зэрэгцээ нэг нь нөгөөгөөсөө ялгаа онцлогтой тодорхой үе шатуудыг дамжин өнгөрүүлж иржээ. Тиймээс монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн үе шатуудыг үечлэх, тэдгээрийн агуулга, хоорондын ялгаа онцлогийг нь гарган тавьж тодорхойлох явдал энэхүү өгүүллийн нэг аспект, зорилт мөн билээ. Монголын улс төрийн сэтгэлгээний үүсэл хөгжлийн түүхийн томоохон үе шатуудыг тодорхойлон гаргаж үечлэх нь асуудлыг загварчилж, хэлбэр хөөж байгаа хэрэг биш, харин ч судалгааны нэг арга мөн бөгөөд тэр нь арга зүйн болон сургалт, заах аргын чухал ач холбогдолтой зүйл.

Үүнийг нэрт эрдэмтэн, академич Ч.Жүгдэр Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ бол (i) эртнээс XIV зууны үе (ii) XV-XVIII зуун, (iii) XIX-XX зууны зааг үе хэмээн хуваан⁵ судалсан байдаг. Бид үүнд XIX-XX зууны үеийг тус бүрд нь монголын улс төрийн сэтгэлгээний хөгжил, түүхийн бие даасан үе шат болгон авч үзэх саналыг нэмэрлэж байна. Энд монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн бие даасан тодорхой үе шатуудыг үечилж гаргах, хуваах хийгээд энэхүү сэтгэлгээний түүхийг цуврал бүтээлүүдэд техникийн үүднээс хуваан авч үзэх хоёр нь хоорондоо холбоотойн зэрэгцээ бас багагүй ялгаатай болохыг тэмдэглэх нь

⁵ Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ФСЭХ, ШУА. Уб., 2008. “Бэмби сан” ХХК.

зүйтэй. Тухайлбал дурдсан үе шат тус бүрийн аль нэгийг түүний агуулга, багтаамж, сэтгэгч төлөөлөгчдийн тоо, сурвалж бичгүүдийн болон үргэлжилсэн цаг хугацааных нь хэмжээ, байдлаас шалтгаалж нэг бүтээлд багтаан авч үзэх боломжгүй хэд хэдэн цуврал бүтээлээр судлах шаардлага гарах болно. Монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн дээрх үе шатууд хоорондоо уламжлал, үзэл санааны нягт хэлхээ холбоотойн хамт бас үүсэл хөгжил, сэтгэлгээний хэв маяг, түүхэн нөхцөл, авч үзсэн асуудал, агуулгад, сэтгэгч төлөөлөгч, бичиж тэмдэглэсэн сурвалж бичиг, түүний төрөл зүйлээрээ багагүй ялгаа онцлогтой байна. Эдгээр зүйл дээрх үечлэлийг гаргаж тавих үндэслэл болж байгаа юм. Тухайлбал эртнээс буюу МЭӨ III зуунаас XIV зууны үе бол монголын улс төрийн сэтгэлгээ анх үүсэн бүрэлдэж төлөвшсөн, холбогдох сурвалж бичгүүдэд анх бичигдэн тэмдэглэгдсэн, сэтгэлгээний уламжлал бий болж дараагийн үеийн үзэл санаа, сэтгэлгээний хөрс суурь болсон зэрэг онцлогтой. Хоёр дахь үе буюу XV-XVIII зуунд монголын улс төрийн сэтгэлгээ, өмнөх үеийн улс төрийн үзэл санаа, сэтгэлгээний уламжлал, нөлөөгөөр цааш хөгжиж, нийгмийн улс төрийн амьдрал, түүний түүхэн томоохон үйл явдал, үзэгдлүүдийг тусган илэрхийлж байсан⁶ бөгөөд бичигдэж тэмдэглэгдсэн сурвалж бичгийн хувьд хөгжин гүнзгийрсэн, түүхийн бичиг, намтрын зохиол, товчис, тууж, хууль цаазын бичиг зэрэг төрөл зүйлээр баяжсан, өргөн хүрээ, агуулгатай болсон байна.

Монголчууд XVII зууны эхэн үеэс эх түүхээ ихээхэн сонирхож, эргэн санах болсны дагуу XVII-XVIII зуунд монголын түүхийн ойллого судар, түүхэн сурвалж бичиг, зохиол бүтээл олноор гарч, энэ үеийн эрдэмтэн мэргэд тэдгээр бүтээлдээ өмнөх үеийн монголын нийгэм, улс төрийн түүхийн талаарх сурвалж бичиг, аман болон бусад мэдээ материалыг эргэн харж авч үзэх, тэдгээрийн агуулга, үзэл санааг шууд болон дам байдлаар дахин өгүүлэх, сэргээн тавих, зааж дурдах, тайлбарлах болсноор нэг ёсондоо монголын түүхийн түүх бичлэг XVII-XVIII зуунд бий болсныг академич Ш.Бира ба бусад эрдэмтэд судалж, нотлон⁷ тогтоожээ. Энэ нь монголын улс төрийн сэтгэлгээний түүх бичлэгийн асуудалд ч холбоо хамааралтай гэж үзэж болох юм. Чухамдаа XVII-XVIII зууны үед зохиогдсон “Хаадын үндсэн хураангуй Алтан товч”, “Эртний монголын хаадын их Шар тууж”, “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Дай Юань улсын болор эрхи”, “Эрдэнийн эрхи” гэх мэт түүхийн зохиол, сурвалж бичгүүдэд өмнөх үеийн монголын улс төрийн сэтгэлгээний ерөнхий агуулга, голлох үзэл санааг ямар нэг хэмжээгээр сэргээж зураглан гаргажээ. Үүнийг эш үндэс болгон эдгээр товчис зохиолууд нь монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн чухал сурвалж бичгүүд мөн хэмээн үзэж болох юм.

Тэгвэл, XIX зууныг монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн бие даасан шинэ үе шат болгон авч үзэх үндэслэл бий. Энэ үед гадаад дотоодын нөхцөл, хүчин зүйлийн нөлөөгөөр монголын нийгмийн амьдрал, түүхэн нөхцөл байдал өмнөх үеүдээс өөрчлөгдөж, тэр нь улс төрийн сэтгэлгээнд тусгалаа олсон, энэ үед гарч ирсэн нэг шинэ чухал зүйл бол улс төрийн сэтгэлгээ нь нийгэм-улс төрийн зүтгэлтэн, томоохон яруу найрагч, зохиолч, соён гэгээрүүлэгч зэрэг түүхэн тодорхой сэтгэгч бие хүмүүсийн⁸ улс төрийн үзэл санаа, сургаал, зохиол бүтээлүүдээр⁹

⁶ Жүгдэр Ч. XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. ШУАХ. Уб., 1984; Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ФСЭХ, ШУА. Уб., 2008. “Бэмби сан” ХХК. 235 дахь тал

⁷ ФСЭХ, ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 10-11 дэх тал

⁸ Нацагдорж Ш. То ван ба түүний сургаал. ШУА-ийн мэдээ сэтгүүл. ШУАХ. Уб., 1966.

⁹ Жүгдэр Ч. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ШУАХ. Уб., 1972; Дашижамц Д. Монгол дахь дэвшил ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд (XIX-XX зууны зааг). ШУАХ.

баяжсан явдал юм. XIX зууны сүүлчээр нийгэм-улс төрийн сэтгэлгээний хэв маяг өөрчлөгдөн шинэчлэгдэх хандлагатай болж, шүүмжлэлт, шинэтгэлийн үзэл санаа товойн гарч иржээ. Энэ хугацаанд улс төрийн амьдрал ба улс төрийн сэтгэлгээний холбоо, харилцан нөлөөлөл өмнөх үеүдийнхээс илүү нягт, идэвхтэй болжээ. XIX зууны монголын их зохиолч, түүхч, сэтгэгч Инжиннаши “Их Юань улсын мандсан төрийн хөх судар” хэмээх гурамсан зохиолдоо XII зууны сүүлч, XIII зууны эхэн үеийн монголын нийгэм, улс төрийн түүхийн 70 гаруй жилийн үйл явдлыг түүхэн романы хэлбэрээр гарган тавих явцад тэр үеийн монголчуудын улс төрийн сэтгэлгээний үзэл санааг¹⁰ дам байдлаар ерөнхийд нь зураглан гаргажээ. Холбогдох зарим ном бүтээлээс тоймлон үзэхэд монголын улс төрийн сэтгэлгээнд шууд ба дам холбогдолтой түүх, хууль цааз, уран зохиолын дурсгалт бичиг, сурвалж ба бусад баримт сэлтийг гадаадын судлаачид XIX зууны эхэн биеэс сонирхон судлах болжээ. Тухайлбал XIX зуунд Н.Я.Бичурин, Г.Гомбоев, Кафаров Палладий, П.С.Паллас, К.Ф.Голстунский, А.М.Позднеев, Г.Н.Потанин, В.П.Васильев нар, XX зууны эхээр Б.Я.Владимирцов, В.А.Рязановский, хожим нь Н.П.Шастина, түүнчлэн Европ, Хятад, Японы зарим эрдэмтэн тэдгээр сурвалж бичгүүдийг сурвалжлан тогтоох, нягтлан үзэж тайлбар хийж нийтлүүлэх, гадаад хэлэнд хөрвүүлэх зэрэг байдлаар судалгааны ажлын эргэлтэд оруулах¹¹ болсон байна. Энэ нь монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг холбогдох сурвалж бичгүүдээр баримтжуулж үндэслэхэд чухал ач холбогдолтой болсон бөгөөд тэгэхдээ яг сэтгэлгээний түүхийн аспектэй зориудын судалгаа хараахан биш байсныг хэлэх хэрэгтэй болов уу.

XX зуун бол монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний өөрчлөлт, хөгжлийн цоо шинэ, сонирхолтой, баялаг агуулгатай үе шат болсныг энд тайлбарлах нь илүүц зүйл. Тухайн ард түмэн, түүнийг төлөөлсөн сэтгэгч мэргэдийн улс төрийн үзэл санаа, сургаал, сэтгэлгээ нь нэг талаас ямар нэг хэлбэр, төрөл зүйлээр бичигдэж тэмдэглэгдэн үлддэг, тэгснээрээ улс төрийн сэтгэлгээний түүхийн эх сурвалж, дурсгалт бичиг, бусад баримт сэлт бүрэлдэж хуримтлагддаг байна. Өөрөөр хэлбэл, XX зууны эхээр тухайн үеийн эрх баригчдаас явуулсан шинэ засгийн бодлого нь феодалын үндсэрхэх үзлийн өрнөлтөд хүчтэй түлхэц үзүүлсэн байдаг. Энэ бол үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэлд хүчин зүтгэх, улмаар үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд уриалан дуудсан монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөх чухал түлхэц болжээ. Угтаа эл хөдөлгөөний үр дүнд тогтсон засаг төр нь феодал ангийн эрх ашгийг хамгаалах зэвсэг болж байсан нь угтаа шашныг улс, үндэсний тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг хэмээн ард нийтээр үзэж, шашны далбаан дор нэгдэн нягтарсан феодалын эх оронч үзлийн бодитой хэрэгжилт байв. Үүнээс улбаалан монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг эхнээсээ тууштай дэмжиж “онолын” үүднээс зөвтгөн үндэслэж ирсэн үзэл санааны өөр нэгэн чиглэл бол соён гэгээрүүлэгч дэвшилтэт-ардчилсан үзэл билээ. Дэвшилтэт-ардчилсан үзэл нь манж-хятадын колоничлогчид, тэднийг аялдан дагагч феодал ноёдын байр суурийг илчлэн харуулаад зогсохгүй, ерөөс феодализмыг нийгмийн байгууллынх нь хувьд эсэргүүцэн үгүйсгэж, феодалын төрийг илүү дэвшилттэй, ардчилсан буюу хөрөнгөтний, бүгд найрамдах төрөөр халах үзэл санааг дэлгэрүүлэн сурталчилж байжээ. Үүгээрээ дэвшилт-ардчилсан үзэл нь монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн үзэл санааны чухал ололт байж, уг тэмцлийн үндэсний хийгээд нийгмийн агуулга, хүрэх үр дүн, эцсийн

Уб., 1970.

¹⁰ ФСЭХ., ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред.

Жамбал А. Уб., 2006, II дэх тал

¹¹ Мөн тэнд., 67, 69, 70, 78, 166, 167 дахь талууд

зорилтыг тухайн үедээ бололцоотой хэмжээгээр илэрхийлэх¹² явдал байжээ.

Нөгөөтээгүүр дээр дурдсан бүхэн нь улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгааны гол хэрэглэгдэхүүн, судлагдахуун болдог. Тэдгээр нь эх сурвалж ба бусад баримт сэлтээр дамжуулж улс төрийн сэтгэлгээний түүхийг тусгайлан судлах, түүний үр дүнг системтэй бичиж тэмдэглэснээр улс төрийн сэтгэлгээний түүх бичлэг бүрэлдэн бий болдог байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн сэтгэлгээний бодит түүх, түүний эх сурвалж, дурсгалт бичиг ба нөгөөтээгүүр улс төрийн сэтгэлгээний түүх бичлэг, түүний судалгаа хоёр хоорондоо нягт холбоотой боловч бас зарчмын ялгаатай, өөр өөр зүйл байдаг. Дэлхийн хэмжээний улс төрийн сэтгэлгээний түүхийн туршлагаас үзвэл, улс төрийн сэтгэлгээний түүх бичлэг нь уг сэтгэлгээний бодит түүхээс нэлээд хугацааны дараа, хожим нь бүрэлдэж бий болдог ажээ. Энэ нь монголын улс төрийн сэтгэлгээний түүх бичлэгт ч нийтлэг хамааралтай аж.

1921 онд Судар бичгийн хүрээлэн байгуулагдаж, улмаар эрдэм судлалынхаа нэгэн чухал чиглэлийг монголын түүх, соёл, уран зохиолын холбогдолтой ховор ном зохиол, сурвалж бичгүүдийг сурвалжлан эрж олох, цуглуулах болсон түүхтэй. Эл ажилд С.Жамьян, Ж.Цэвээн, Д.Дашням, Б.Ширнэндамдин болон бусад хүмүүс гар биеэр оролцсон нь бий. Түүний үр дүнд ховор чухал сурвалж бичиг, ном дэвтэр нэлээдийг олж цуглуулсны дотор Галсангийн *“Эрдэнийн эрхи”*, *“Арван буянт номын цагаан түүх”*, Лувсанданзангийн *“Алтан товч”* орсон байх ба *“Алтан товч”*-ийг 1937 онд нийтлүүлж уншигчдын хүртээл болгожээ. Эдгээр нь хожим монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг холбогдох сурвалж бичигт тулгуурлаж судлан боловсруулахад зайлшгүй шаардлагатай урьдач бэлтгэл болсноороо түүхэн ач холбогдолтой байв. Түүнчлэн монголын нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээний түүхийг монголын эрдэмтэд өөрсдөө авч үзэж судлах шинэ чухал үйл хэрэгт анхны алхам, оролдлого хийсэн эрдэмтэн бол Ж.Цэвээн¹³ юм. Тэрбээр А.Туруновтой хамтарч *“Халх журам”*-ын тухай бүтээлийг 1923 онд Эрхүүгийн их сургуулийн эрдэм шинжилгээний бичигт, хожим өөрөө дагнаж бичсэн *“Монгольские летописи XVII века”* хэмээх бүтээлээ 1936 онд Ленинградд нийтлүүлжээ. Жамсрангийн Цэвээн эл бүтээлдээ *“Цагаан түүх”* ба түүхийн бусад сурвалж бичгийн нийгэм-улс төрийн үзэл санааг хөндсөн нь туйлын сонирхолтой, чухал зүйл хэмээн үзэж болно. Холбогдох мэдээ баримт, ном зохиолоос үзэхэд 1920-иод оны сүүлч, 1930-аад оны эхээр монголын түүхийг судлах, түүхийн ном бүтээл хэвлэн гаргах үйл хэрэгт өмнөх үеүдээс чанарын ялгаатай ахиц ололт гарчээ. Энэ үед монголын түүхийг эртнээс тухайн үе хүртэлх үеэр цэгцтэй, шинэ цагийн түүхийн ухааны үлгэр жишээгээр авч үзэн гаргаж тавих эхлэл тавигджээ. Тухайлбал 1928 онд Ч.Бат-Очирын *“Монгол улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг”*; А.Дэндэвийн *“Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр”*; 1934 онд А.Амарын *“Монголын товч түүх”* тэргүүн дэвтэр; А.Дэндэвийн *“Монголын товч түүх”* нийтлэгдсэн бол Ч.Дэмчигдорж *“Юань улсын судар”*-ыг 1928 онд орчуулж дуусгажээ. Эдгээр түүхчид бүтээлүүддээ Монголын нийгэм, төрийн түүхийг ерөнхийд нь хураангуйлан өгүүлэх явцад монголын улс төрийн сэтгэлгээний талаар зарим зүйлийг дурдаж¹⁴ тэмдэглэсэн байна. Нөгөөтээгүүр, хувьсгалын дараа Монголын нийгмийн амьдралын бүх хүрээнд шинэчлэлийн үйл явц өрнөсөн нь Монгол оронд хөгжлийн ойрын болон

¹² Цогтсайхан Д. Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Бүтээлийн эмхэтгэл. Эмхэтгэсэн. Жаргал Ц., Гэрэл Ц. Уб., 2015, 172 дахь тал

¹³ Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ФСЭХ, ШУА. “Бэмби сан” ХХК. Уб., 2008. 507 дахь тал

¹⁴ ФСЭХ, ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 11-12 дахь тал

хэтийн хандлагыг бүрэлдүүлэх улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд зарчмын хийгээд ардчилал, шинэчлэлийн үзэл санаа тууштай дэвшигдэх болжээ. Тухайлбал, улс төрийн салбар дахь өөрчлөлт нь Монгол оронд бүгд найрамдах засаг тогтоож, хуулийг дээдлэх үзэл санааг нийгэмд төлөвшүүлэн, улмаар Монголд парламентын ёсыг бүрэлдүүлэх угтвар нөхцөлийг бий болгоод зогсохгүй нийгмийн гишүүд гарал угсаа, хөрөнгө чинээний байдлаас үл хамааран адил тэгш эрхтэй болсон нь ардчилсан өөрчлөлтийн нэн чухал ололт байв. Түүнчлэн төр шашны харилцааг хуулиар зохицуулах, ард олны шүтэх бишрэх эрх чөлөөг төрөөс хангаж байсан бөгөөд монголын нийгэмд олон ургальч үзэл төлөвшиж эхэлсэн зэрэг нь тухайн үеийн монголын нийгэмд ардчилсан ёс бүрэлдэж эхэлсний нэн тодорхой илрэл болсон¹⁵ хэмээн үзэж болох юм.

Хожим 1950-иад онд Монгол-зөвлөлтийн түүхчдийн хамтран зохиосон “БНМАУ-ын түүх” (1954) нийтлэгдсэн нь монголын түүхээр гарсан анхны дорвитой бүтээл болжээ. Үүний дараах үеэс манай эрдэмтэд монголын нийгэм, төрийн түүх, түүний тодорхой асуудлуудыг тусгайлан судалж эхэлсэн байна. Энэ явцад нийтлэгдэн гарсан бүтээлүүдийн дотроос монголын улс төрийн түүх, улс төрийн сэтгэлгээний түүхтэй холбоотой бүтээлүүдээс Ш.Нацагдоржийн *“Ар Монголд гарсан ардын хөдөлгөөн”* (1956), *“Чингис ба түүний дүү Хасар нарын зөрчил”* (1957), *“Цагаан түүхийн тухай хэдэн үг”* (1958), С.Жалан-Аажавын *“Халх журам бол Монголын хууль цаазын дурсгалт бичиг мөн”* (1958) хэмээх бүтээлүүдийг онцлон дурдах нь зүйтэй гэж үзэв. Чухам эдгээр бүтээл гарснаар монголчуудын улс төрийн сэтгэлгээний түүхийг түүний өөрийнх нь аспетээр тусгайлан судлах эхлэл тавигдсаныг гэрчилж буй хэрэг бөлгөө. Монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээ нь түүхэн хөгжлийн явцдаа уран зохиолтой нягт уялдаатай хөгжиж ирсэн онцлогтой юм. Үүнтэй холбоотойгоор Ц.Дамдинсүрэн 1957 онд *“Монголын уран зохиолын тойм”* бүтээлийг, 1959 онд *“Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой”* хэмээх цоморлогийг нийтлүүлсэн нь Монголын уран зохиолын судалгаа төдийгүй гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг судлах, тэдгээрийн эх сурвалж, дурсгалт бичгүүдийг цуглуулж нийтлэх ажлын үндэс суурь болжээ.

Энэ үеэс хойш монголчуудын улс төрийн сэтгэлгээний түүхийг тусгайлан судлах ажил амжилттай хийгдэх болсон. Тухайлбал, 1960-аад оны эхээс монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн тодорхой асуудлуудыг диссертаци, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээлийн түвшинд тусгайлан судлах болсноор эл чиглэлийн судалгаа бие даан хөгжиж, улмаар тодорхой амжилтад хүрч ирсэн нь бий. Тодруулбал, академич Ч.Жүгдэр 1960-аад оны эхээс 1980-аад оны хоёрдугаар хагаст мөнхүү дурдсан асуудлыг шат дараатай, системтэйгээр судалж *“ХIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил”* (Уб., 1972), *“З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл”* (Уб., 1978), *“ХV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм”* (Уб., 1984), *“Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ”* (Уб., 1987) гэсэн дөрвөн томоохон цуврал бүтээл, олон тооны эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллүүдийг бичиж туурвисан нь монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг эртнээс XX зууны эхэн хүртэлх үеэр нь манайд анх удаа цогцолбор байдлаар судлан гаргаж тавьсан нь шинжлэх ухааны асар их ач холбогдолтой үйл хэрэг болсон юм. Мөн Ч.Жүгдэрийн бичсэн *“Монголын нийгэм-*

¹⁵ Даидаваа Ч. Улаан түүх (Коминтерн ба Монгол). Хоёр дахь удаагийн хэвлэл. ред. Бат-Очир Л. Түүхийн хүрээлэн, ШУА, СУИС, Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль. . “Бэмби сан” ХХК. Уб., 2019, 85 дахь тал

улс төрийн ба гүн ухааны сэтгэлгээний түүхэн хөгжлийн зарим асуудал” хэмээх эрдэм шинжилгээний чухал өгүүлэл 1966 онд “ШУА-ийн мэдээ” сэтгүүл (1966, №3)-д нийтлэгдсэн бол, Ш.Нацагдорж “То ван ба түүний сургаал” хэмээх бие даасан судалгааны бүтээлийг 1968 онд тус тус нийтлүүлжээ. Түүнчлэн эрдэмтэн судлаач Г.Дэлэг “Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” нэртэй эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт томоохон бүтээл туурвин 1965 онд нийтлүүлсэн бөгөөд түүндээ XX зууны эхэн үеийн тогтмол хэвлэлд туссан монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний тоймыг гаргаж тавих болсон. Үүний тод жишээ болгон академич Ш.Нацагдорж нарын манай эрдэмтэдийн дотроос анх удаа 1950-иад оны дунд үеэс, зарим талаар 1940-өөд оноос монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн зарим тодорхой асуудал, тухайлбал “Монголын нууц товчоо”, “Цагаан түүх”, “Улаан хацарт”, “Халх журам”, 1960-аад онд “То вангийн сургаал”, 1980-аад оны сүүлчээр Чингисийн нийгэм-улс төрийн үзэл санаа болон нийгэм-улс төрийн ба хууль цаазын сэтгэлгээний бусад дурсгалт бичиг, эх сурвалжуудад анхаарал хандуулж, тэдгээрийн үзэл санааг судлан, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, товхимлуудыг нийтлүүлжээ. Энэ бол монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаа өөрийн аспетээр бие дааж ялгаран хийгдээгүй, гэхдээ түүнийг эхлүүлэхэд зайлшгүй шаардлагатай урьдач бэлтгэл судалгааны ажлын байдалтайгаар монголын түүхийн ерөнхий судалгаа, түүхийн сурвалж бичгүүдийг нягталж тайлбар үйлдэн нийтлүүлэх ажлын хүрээнд хийгдсэнээрээ онцлогтой. Цаашилбал, монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг бие даасан байдлаар судлан боловсруулах эрдэм шинжилгээний шинэ чиглэлийг бий болгох эхлэл тавигдсан гэж хэлж болохоор байна. Угтаа энэхүү судалгааны чиглэл нь тохиолдлын зүйл биш, харин ч тухайн үеийн монголын нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдрал, монголын нийгмийн шинжлэх ухааны байдал, тэдгээрт нөлөө оролцоотой байсан бусад хүчин зүйлстэй нөхцөлдсөн нийгэм-соёлын чухал үзэгдэл байсныг энд онцлох нь зүйтэй.

Өгүүлэн буй сэдвийн хүрээнд монголын нийгэм, соёл, тэр дотор нийгмийн шинжлэх ухааны хувьд Дэлхийн II дайны уршгаар бий болсон хүн ам, нийгэм, эдийн засаг, аж ахуйн их хэмжээний хохирол, бэрхшээлийг даван туулах, улмаар эдийн засгийг цааш сэргээж шинэ шатанд гаргах, эрчимтэй хөгжүүлэхэд голлон анхаарах болжээ. Энэ нь социаль хүрээний хувьд эдийн засгийн өсөлтөд тулгуурлаж хүн амын материаллаг амьдралыг сайжруулах, эрүүл мэнд, соёл, боловсролын түвшнийг ахиулах, түүнчлэн улс төрийн амьдралд тухайн үед Монгол болон ЗХУ-д тогтон ноёрхож байсан ардчилсан бус, хатуу дэглэм аажмаар суларч, эдгээр дэглэмд зарим талын “эерэг” өөрчлөлт гарах болсны нөлөөгөөр нийгэм дэх улс төрийн болон үзэл суртлын хатуу хяналт, дарамт тодорхой хэмжээгээр багасаж, хүмүүсийн үзэл ухамсар, ялангуяа сэхээтэн, тэр дотор нийгэм-хүмүүнлэгийн салбарын сэхээтэн мэргэжилтнүүдийн оюун санаа, сэтгэхүйн хүлээс, айдас болгоомжлол мэдэгдэхүйц багасаж эхэлсэнтэй шууд холбоотой.


1970-аад оны эхэн үеэс монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаа үлэмж гүнзгийрч, улмаар доктор Д.Дашжамц “Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд: XIX-XX зууны зааг” (УБ., 1970) нэртэй бүтээлийг, Ч.Жүгдэр “XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил” (УБ., 1972) хэмээх нэгэн сэдэвт бүтээлийг тус тус нийтлүүлсэн байна. Энэ бол монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаанд академич Ш.Нацагдорж, академич Ч.Жүгдэр нарын оруулсан жинтэй хувь нэмэр төдийгүй, тэдний эл дурдсан суурь бүтээлүүдийн тухай товч боловч тусгайлан өгүүлэх зайлшгүй шаардлагатай болохыг харуулж буй хэрэг. Учир нь

дурдсан эерэг өөрчлөлттэй нөхцөлдөн манай оронд орчин үеийн шинжлэх ухаан, тэр дотор нийгмийн шинжлэх ухаан өмнөх үеийнхээсээ ахиж, хөгжлийн шинэ шатанд дэвших нааштай өөрчлөлт гарах болсонтой холбоотой. Өмнө нь түүх, хэл шинжлэл, уран зохиол судлал голлож байсан нийгмийн шинжлэх ухаанд дифференциац буюу салбар ухаануудын ялгарал явагдаж философи, ёс зүй, төр, эрх зүйн ухаан хийгээд тэдгээрийн түүх буюу философи, ёс зүй, нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээний түүхийн ухааны эх үндэс бий болж тэдгээрийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдыг бэлтгэх болсон. Тухайлбал, дээр нэгэнтээ өгүүлсэнчлэн, академич Ш.Нацагдорж манайд 1950-иад оны дунд үе хүртэл тусгайлан судлагдаж байгаагүй монголын нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээний түүхийг нийгмийн сэтгэлгээний түүхийн аспектээр, бие даасан байдлаар судлан боловсруулах шинэ судалгааг санаачлан эхлүүлсний гол илрэл мөн. Эл санаачилга нь цаашдаа түүний тодорхой, чухал асуудлуудыг шинжлэн авч үзэх, улмаар тухайлсан салбар шинжлэх ухааны судалгааны чиглэлийн үндэс суурийг тавьсан нь асар их ач холбогдолтой үйл хэрэг болсон юм.

Учир ахул, дэлхийн олон янзын чиглэл сургууль, онол сургаалын янз бүрийн төлөөлөгчид, судлагчид улс төрийн сэтгэлгээний түүхийг судлахдаа олон янзын арга зүй, хандлага, үзэл онолыг баримталсан байдаг. Үүнийг ч манай эрдэмтэд монголын ард түмний оюуны соёл, сэтгэлгээний хувьд мөн нэгэн адил нийтлэг шинжтэйг харуулахын сацуу улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаанд түүний онол, арга зүй чухал ач холбогдолтой болохыг онцолсон нь зүйн хэрэг ажээ. Ном бүтээлээс үзэхэд, судлаачид улс төрийн сэтгэлгээ бол *нэгдүгээрт*, тухайн цаг үеийн улс төрийн бодит байдал, улс төрийн амьдралыг тодорхой үзэл санаа, онол, сургаал, номлолын хэлбэрээр тусган илэрхийлсэн байдгийг, *хоёрдугаарт*, улс төрийн сэтгэлгээ нь бодит байдлын идэвхгүй тусгал төдий биш, өөрийн дотоод логик, онцлог, бие даасан байдал, идэвхт чанартай, энэ шинжээрээ улс төрийн амьдралаас заримдаа түрүүлж илүү хөгжсөн байдгийг, *гуравдугаарт*, улс төрийн сэтгэлгээг судлан шинжилж нэгтгэн дүгнэх гол, чухал зарчим бол асуудалд түүхэн тодорхой хандах зарчим байдгийг хүлээн зөвшөөрч баримталдаг байна. Энэ нь ч өнөөгийн олон эшт үзэл, чөлөөт сэтгэлгээний түвшнээс ахин дахин нягтлах, улмаар улс төржсөн эсхүл үзэл сурталжсан байр сууринаас хандалгүйгээр илүү шинжлэх ухаанч зарчмаар хандахыг биднээс шаардаж буй. Монгол хүн аливаад амьдралын хэрсүү ухаанаар уужуу тайван ханддаг, эв эеийг эрхэмлэдэг, төрд хандах хандлага нь үнэт зүйлс-ёс суртахууны шинжтэй гэж хэлж болно. Чингэхлээр монголчуудын төрт ёсны сэтгэлгээ тал нутгийн нүүдэлчдийн сэтгэхүй, үзэл бодол, хамтран аж төрөхүй, ёс заншлаас сурвалжтай нь эргэлзээгүй билээ. Нөгөө талаар, монголчуудын ертөнцийн тухай төсөөлөлд орон зайн ухагдахуун чухал байр эзлэх бөгөөд тэр нь дээд тэнгэр, эх нутаг, уул ус, гал голомт, өвөг дээдсээ шүтэн бишрэхээр дамжин төрөө дээдлэх уламжлалт үзэлд нэвт шингэсэн байдагтай шууд холбоотой.

Хоёр. Шинжлэх ухаан коммунизмын онол ба марксист-ленинист сургаалын үе (1972-1990)

ХИХ-ХХ зууны зааг үе хүртэл үргэлжилж хөгжсөн монголын улс төрийн уламжлалт сэтгэлгээ ба түүний түүх бичлэг хийгээд 1920-иод оноос 1990-ээд оны эхэн хүртэл хийгдсэн улс төрийн чанартай судалгааг авч үзсэн асуудал, хандсан аспект, агуулгыг нь харгалзан үзэж дотор нь ерөнхий чиглэл, салбараар ангилан авч үзвэл дараах зураглал гарч буй.



1920-иод оноос 1990-ээд оны эхэн хүртэлх хугацаанд төр, улс төрийн нам, улс төр-олон нийтийн байгууллагын шинж чанар хосолсон үйлдвэрчний эвлэл, залуучууд, эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллага, бүхэлдээ улс төрийн системийн онол, түүх, түүнчлэн хувьсгал, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, анги, ангийн тэмцэл, дайн цэрэг арми, сонгуулийн асуудлаар олон талтай судалгаа хийгдэж улмаар олон арван ном бүтээл нийтлэгдэн гарчээ. Тэдгээрээс зарим нэг гол бүтээлүүдийг* дараах байдлаар дурдвал:

улс төрийн түүх, хууль тогтоох үйл ажиллагааны талаар	○ Ц.Балхаажав. Төрийн тухай асуудал ба ардын төрийн хувьсгалт үйл ажиллагаа. Уб., 1966 ○ С.Жалан-Аажав. Ардын хувьсгалт төрийн хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн чиглэл. (1921-1940). Уб., 1967 ○ Б.Цэдэн. Монгол –Зөвлөлтийн найрамдал ба МАХН. Уб., 1967 ○ Б.Сангиданзан. Хувьсгалт ардчилсан шатан дахь ардын төрийн гүйцэтгэсэн үндсэн үүргүүд. Уб., 1974 ○ С.Дамба. БНМАУ-ын төрийн хөгжилт. Уб., 1974 ○ М.Санждорж. Ардын төрийн түүх. Уб., 1974 ○ Л.Бат-Очир. Монгол оронд ард ангийн хувьсгалт нам үүсэн байгуулагдсан асуудалд. 1918-1921. Уб., 1979 ○ О.Амархүү. Төрийн захиргааны дээд байгууллагууд. Уб., 1986 ○ Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз. 1911-1920. Уб., 1989
залуус, эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллагын талаар	○ А.Маамуу. МХЗЭ-ийн түүхээс. Уб., 1965 ○ Ш.Магван. Монголын үйлдвэрчний эвлэлийн соёл, хүмүүжлийн ажил. Уб., 1971 ○ О.Бямбажав. Монголын хувьсгалт залуучуудын эвлэл. Уб., 1972 ○ Д.Цэрэндорж. Хувьсгалт уламжлал ба залуучууд. Уб., 1974 ○ Э.Чимэдцэрэн. БНМАУ-д эмэгтэйчүүдийг нийгмийн дарлалаас чөлөөлсөн түүхэн туршлага. Уб., 1976 ○ Д.Зундуй. БНМАУ-д эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг хамгаалж байгаа нь. Уб., 1979 ○ С.Удвал. Монголын эмэгтэйчүүд 60 жилд. Уб., 1981
дайн, цэрэг арми, хууль хамгаалах, хянан шалгах байгууллагын талаар	○ Л.Тойвон. Дайнууд ба армийн гарал үүсэл, түүний мөн чанар. Уб., 1943 ○ Хязгаарын цэргийн түүхэн замнал. Уб., 1965 ○ П.Дорж. Улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлж талаар МАХН-аас явуулсан бодлого (1929-1939). Уб., 1969 ○ Монголын ардын армийн дайчин замнал. Уб., 1979 ○ БНМАУ-ын зэвсэгт хүчин. Уб., 1981 ○ М.Санждорж, Ч.Бавуу. БНМАУ-ын хянан шалгах байгууллагын түүхэн замнал. Уб., 1982 ○ Д.Гомбосүрэн. Хувьсгалын ардчилсан шатан дахь БНМАУ-ын зэвсэгт хүчний байгуулалтын зарим асуудал. Уб., 1983 ○ Д.Шагдар, П.Дагвадорж. Хилийн цэргийн 50 жил. Уб., 1983 ○ Б.Даваасүрэн. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа. Уб., 1990

* ШУА-ийн Философин хүрээлэнгийн эрдэм шинжилгээний номын сангийн фондод бүртгэлтэй болон хадгалагдаж буй ном бүтээлүүдээс энд дурдсан болно.

улс төрийн намын түүх, түүний онолын асуудлаар	○ Л.Санжаа. Намын программуудын тухай. Уб., 1967 ○ С.Ичинноров. Монгол ардын нам гэдэг хувьсгалт байгууллага. Уб., 1973 ○ Ц.Намсрай. Капитализмыг алгассан орнуудад социалист нийгмийн давхрага үүсэж хөгжсөн нь. Уб., 1975 ○ Н.Дамба. МАХН-ын эгнээ хөгжиж бэхжсэн нь. Уб., 1975 ○ Б.Лигдэн. МАХН бол социалист нийгмийн улс төрийн системийн удирдах хүч мөн. Уб., 1978 ○ Ж.Болдбаатар. Социалист байгуулалтаар МАХН-ын удирдах роль өсөн нэмэгдэж байгаа нь. Уб., 1982 ○ Ц.Буянтогтох. БНМАУ-ын улс төрийн системд МХЗЭ-ийн гүйцэтгэл үүрэг. Уб., 1985 ○ С.Дамдинсүрэн. МАХН дэлхийн коммунист хөдөлгөөнтэй холбоо тогтоож хөгжүүлсэн нь. (1921-1940). Уб., 1971 ○ МАХН-ЗХУКН, Социализмын төлөө ах дүүгийн ёсоор хамтран тэмцсэн түүхэн туршлага. Хамтын бүтээл. Уб., 1971 ○ Д.Даш. Ардын хувьсгалын манлай хүчин. Уб., 1972 ○ Б.Лигдэн. БНМАУ-ын гадаад харилцааг хөгжүүлэх талаар МАХН-аас явуулсан үйл ажиллагаа (1945-1970). Уб., 1976 ○ Б.Лхамсүрэн. МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь. Уб., 1975 ○ Г.Лхагвасүрэн. Ардын хувьсгалын үе дэх МАХН-ын стратеги, тактикийн зарим асуудал. Уб., 1977 ○ МАХН ба Коммунист Интернационал (орос хэлээр). Хамтын бүтээл. Уб., 1979 ○ МАХН үүсэж хөгжихөд олон улсын коммунист хөдөлгөөний тусламжийн роль, ач холбогдол. Уб., 1978 ○ Х.Магсаржав. МАХН-ын эгнээ өргөжин бэхжсэн нь (1921-1924). Уб., 1979
--	---

хувьсгал, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, анги, ангийн тэмцлийн асуудлаар	○ Л.Тойвон. БНМАУ-ын сонгуулийн систем. Уб., 1950 ○ Ш.Нацагдорж. Ар монголд гарсан ардын хөдөлгөөн. Уб., 1956 ○ Б.Түдэв. БНМАУ-ын ажилчин ангийн түүх. Уб., 1963 ○ Д.Цэдэв. Их шавь. Уб., 1964 ○ С.Норовсамбуу. Капитализмын өмнөх харилцаа ноёрхон байсан орнуудад ялсан ардчилсан ба социалист хувьсгалын харьцаа, онцлогууд. Уб., 1965 ○ С.Пүрэвжав, Д.Дашжамц. БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь (1921-1940). Уб., 1965 ○ Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. Уб., 1969 ○ Октябрийн хувьсгал ба Монгол орон. Хамтын бүтээл. Уб., 1969 ○ Б.Лигүү. Монгол ардын хувьсгал ба шинэ сэхээтэн. Уб., 1971 ○ Ц.Балхаажав. БНМАУ-ын ангийн харилцааны хөгжил. Уб., 1972 ○ И.Дашням. БНМАУ-ын сонгуулийн систем. Уб., 1975 ○ Ш.Жумдаан. БНМАУ-д ажилчин анги, хоршоолсон ардын эдийн засгийн холбоо үүсэж тогтож хөгжсөн тухай. Уб., 1978
--	---

төрийн гадаад бодлого, олон улсын харилцааны асуудлаар улс төрийн аспектэй судалгаа	○ Ц.Пунцагноров. Америкийн империализм бол монголын ард түмний заналт дайсан мөн. Уб., 1953 ○ Б.Лхамсүрэн. Внешняя политика МНР (1943-1957). Уб., 1958 ○ Б.Лигүү. Из истории русско-монгольских отношений в конце XIX начале XX века. (диссертаци). 1958 ○ Д.Хүрэлбаатар. Монгол гүрний элчин харилцаа. (ХШ зуун) Уб., 1964 ○ Ш.Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа (1850-1919). Тэргүүн дэвтэр. Уб., 1971 ○ Н.Дангаасүрэн. Гурав дахь ертөнц. Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. Уб., 1977 ○ Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1976). Хамтын бүтээл. Уб., 1981 ○ Ц.Самдангэлэг. Зөвлөлт-Монголын армиуд Халх голд Японы түрэмгийлэгчдийг бут цохисон нь. Уб., 1981 ○ С.Дамдинсүрэн. Монгол Ардын Хувьсгал-дэлхийн хувьсгалт үйл явцын бүрэлдэхүүн хэсэг. Уб., 1983 ○ Л.Бат-Очир. МАХН фашизм, милитаризмын эсрэг тэмцэлд ард түмнээ зохион байгуулсан нь (1941-1945). Уб., 1985 ○ Ж.Бор. Монголын улс төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал. Уб., 1988 ○ Өнөөгийн Ази: Дайн энхийн асуудал. Хамтын бүтээл. Уб., 1989
---	---

Тэгвэл, 1940-өөд оноос хойш хийгдсэн түүхийн судалгааны хүрээнд монголын төр, цэрэг, намын зүтгэлтэн, удирдагчид бүхий түүхэн бие хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааг бодит баримт түшин, тэдний аж төрж, зүтгэн тэмцэж байсан түүхэн нөхцөл, цаг үетэй холбож авч үзэж судалсан олон ном бүтээл нийтлэгдсэн байна. Тэдгээр нь улс төрийн шинжлэх ухааны хошуучлал буюу лидер судлалын чиглэлтэй нэлээд ойролцоо байгаа нь ажиглагддаг. Гэхдээ энэ нь тэдгээр судалгаанд лидер судлалд баримталдаг үзэл баримтлал, арга зүй, ойлголт, ангилал, судалгааны аргуудыг хэрэглэсэн гэсэн үг биш юм. Манай орны түүхийн ухаанд төр, цэрэг, намын нэрт зүтгэлтнүүдийн амьдрал үйл ажиллагаа, намтрыг судлан бичих явдал 1940-өөд оноос чухал болон тавигдаж бие даасан ном зохиол нийтлэгдэх болжээ. Ийнхүү түүхэн зүтгэлтнүүдийн намтар судлал, бичлэг идэвхэжсэн нь Дэлхийн II дайны үед хүмүүсийг цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэх зорилт нэн чухал болсонтой нягт холбоотой байжээ. Эдгээрээс өгүүлэн буй сэдвийн хүрээнд холбогдох зарим нэгийг

НЬ ОНЦЛОХЫГ ЗОРИВ.


түүхэн зүтгэлтнүүдийн намтар судлал	Ц.Цэдэнжав. Хатанбаатар Магсаржав. Уб., 1941 Ц.Цэдэнжав. Партизан Хасбаатар. Уб., 1942 Х.Чойбалсан. Ардын Хатанбаатар Магсаржав. Уб., 1942 Ш.Нацагдорж. Сүхбаатарын намтар. (Д.Сүхбаатарын амьдрал, цэрэг-улс төрийн үйл ажиллагаа). Уб., 1943 Г.Навааннамжил. Дайсны ард нэвтэрсэн нь. Уб., 1944 Г.Навааннамжил. Жанжин Чойбалсан баруун замын байлдаанд. Уб., 1945 Ш.Нацагдорж. Манлайбаатар Дамдинсүрэнгийн товч намтар. Уб., 1945 Ю.Цэдэнбал. Нөхөр Чойбалсангийн амьдрал, үйл явдлын тухай. Уб., 1945
нэгэж эх оронч үзэл хүмүүжүүлэх хүрээнд	Г.Навааннамжил. Зоригт баатар Тогтохын намтар. Уб., 1946 Манай их удирдагч нөхөр Янжмаагийн 25 жилийн хувьсгалт бүтээл. Уб., 1946 Х.Чойбалсан. Сүхбаатар бол МАХН-ын жолоодогч бөгөөд түүнийг зохион байгуулагч мөн. Уб., 1955 Б.Ширэндэв. Хичээнгүй сайд Цэрэндорж (1868-1928). Уб., 1965 Сүхбаатарын тухай дуртатгалууд. Уб., 1965 Д.Ядамсүрэн. Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж. Уб., 1967 Л.Бат-Очир, Д.Дашжамц. Д.Сүхбаатарын намтар. Уб., 1969 Б.Ширэндэв. Ардын Хатанбаатар Магсаржавын намтар. Уб., 1978 С.Ичинноров. Монголын ард түмний гарамгай хүү. Уб., 1983 Д.Даш. Д.Сүхбаатарын тухай түүхэн тэмдэглэл. Уб., 1988 А.Дашням. Солийн Данзан. Уб., 1990 Л.Бат-Очир. Бодоо сайд. Уб., 1991

Дээр дурдсанчлан 1990-ээд оноос өмнө хийгдэж байсан улс төрийн түүхийн судалгааны хүрээнд түүхэн бие хүмүүсийн намтар судлал нь түүний нэгэн чиглэл болон тавигдаж түүгээр ХХ зууны эхэн үе, ялангуяа 1921 оны ардын хувьсгал ба түүний дараах нийгмийн хувьсгалт өөрчлөлтийн үйл хэрэгт хүчин зүтгэж байсан монголын төр, нам, цэргийн томоохон зүтгэлтэн бүхий түүхэн бие хүмүүс, нэг ёсны лидерүүдийн амьдрал, нийгэм-улс төр, цэргийн үйл ажиллагааг судлан илэрхийлэхийг чухалчилж байв. Чингэхдээ урьд нь үзэл суртал, улс төрийн тодорхой учир шалтгаануудын улмаас авч үзэж судалж байгаагүй, бие даасан ном зохиол, бичигдээгүй төр, нам, цэргийн зүтгэлтнүүдийн талаар олон ном бүтээл нийтлэгдэн гарсныг энд тэмдэглэх хэрэгтэй. 1990-ээд оноос дээрх нөхцөл, шалтгааныг илүү тодруулах, тэдгээрийн нийгэм-улс төрийн үзэл санааны давуу болон сул талуудыг тодруулахыг зорих болсон нь ийнхүү төр, нийгмийн зүтгэлтэн түүхэн бие хүмүүсийн намтар судлал эрс идэвхжих суурь болсон гэж үзэж болно.

Манай оронд 1990-ээд оноос өмнөх үед түүх, философи, төр, эрх зүйн асуудал, зарим тохиолдолд монголын уран зохиол судлалаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын дотроос монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, түүний үр дүнд гарсан ном зохиолууд өнөөгийн улс төрийн шинжлэх ухаанд шууд учир холбогдолтой, ихээхэн ач тустай байгааг онцлон тэмдэглэвэл зохино. Учир нь улс төрийн сэтгэлгээ, сургаалын түүх бол улс төрийн шинжлэх ухааны бүтцэд чухал байр суурь эзэлдэг, түүний үзэл санааны түүхийг бүрдүүлдэг онцлогтой. Тэр ч утгаараа 1990-ээд оноос өмнө монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, ялангуяа академич Ч.Жүгдэрийн туурвисан цуврал суурь бүтээлүүд “Улс төрийн боловсролын анхны мэдэгдэхүүн” (Уб., 1972), түүнчлэн Д.Дашжамц, Б.Дүгэр “Нийгэм улс төрийн товч толь” (Уб., 1973), “Улс төрийн мэдлэгийн үндэс” (Уб., 1975), “Улс төрийн лавлах” (Уб., 1986) зэрэг эрдэмтдийн ном бүтээлүүдээс харагддаг. Улс төрийн аспетээр судалгаа боловсруулалтын хүрээн дотор улс төрийн ерөнхий мэдлэг бүрдүүлж бий болгох, түүнийг холбогдох сурах бичиг, гарын авлага, сэдэвчилсэн эмхэтгэл, толь бичиг, лавлах материал зэрэг хэлбэрээр эмхлэн системчилж их, дээд, тусгай, дунд болон техник-мэргэжлийн сургуулиудын оюутан, суралцагчид, нам, үйлдвэрчний болон залуучуудын эвлэлийн улс төрийн сургуульд зориулж нийтлэн гаргаж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй. Тухайн үед одоогийн улс төрийн шинжлэх ухааныг албан ёсоор

хүлээн зөвшөөрдөггүй, бие даасан тусгай шинжлэх ухаан гэж үздэггүй байсны улмаас түүний онолын мэдлэгийн тогтолцоог “улс төрийн мэдлэг”, “улс төрийн мэдлэгийн үндэс” гэх зэргээр нэрлэн томъёолж марксист онол, сургаалын үндсэн дээр боловсруулж нийтэд судлуулан түгээдэг байсныг ийнхүү тухайлан онцлох учиртай.

Үүнээс үзэхүл, манай оронд 1920-иод оноос 1990-ээд он хүртэлх үед эрх баригч ганц нам буюу МАХН-ын үйл ажиллагааны онол-үзэл суртлын үндэс нь марксизм бөгөөд түүний ленинист хувилбар орших болсноор марксизм-ленинизмын онол сургаалын гурван үндсэн бүрдэл хэсгийн нэг болох шинжлэх ухааны коммунизмын онол бат бөх оршин тогтносон нь тухайн үедээ марксизмын нийгэм-улс төрийн сургаал мөн хэмээн үзэж байв. Үүний хэтийн зорилгыг тодорхойлохдоо капитализмыг хувьсгалт ёсоор халж, түүний оронд социалист нийгэм, ирээдүйд коммунист нийгэм байгуулах зүй тогтол, арга замыг судлах явдал хэмээн тодорхойлжээ. Тиймээс ч Монгол оронд социалист нийгэм байгуулах зорилт тавигдаж улмаар түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тууштай тэмцэж байсан учраас шинжлэх ухаан коммунизмын онолыг их дээд сургуулиудад тусгай хичээл болгон зааж судлуулах зорилгоор МУИС-д Шинжлэх ухаан коммунизмын онолын тэнхимийг, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнд Шинжлэх ухаан социализмын онолын секторыг 1978 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор тус тус байгуулан ажиллуулж ирсэн¹⁶ түүхтэй. Үүний тод илрэл бол:



Энд дурдан буй аж төрөх ёсны судалгааны үр дүнд “БНМАУ-д социалист аж төрөх ёс төлөвшин хөгжиж буй асуудал” (ШУА, ФСЭХ, УБ., 1982) хамтын бүтээл хэвлэгдэн гарчээ. Эл бүтээлд нийгэм, бие хүний аж төрөх ёс, амьдралын хэв маягийг судлах онол, арга зүйн асуудал, Монгол оронд хүмүүсийн хуучин аж төрөх ёс өөрчлөгдөж шинэ шинжтэй болсон үйл явц, тус оронд шинэ аж төрөх ёсыг хэвшүүлж хөгжүүлэх, нийгэм, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, соёл, ёс суртахуун, гоо зүйн асуудлуудыг тал бүрээр судлан боловсруулсан онол, арга зүйн хүрээнд авч үзэж, нэгтгэн дүгнэсэн байна. Гэсэн авч, эл бүтээлийг өнөөгийн өнцгөөс харвал шүүмжлэх асуудал багагүй байдаг. Тухайлбал, тухайн үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс үнэн бодитойгоор авч үзэхийг хичээсний сацуу тухайн цаг үеийн үзэл суртлын өнцгөөс хандсан хандлага, улс төрийн бодлого, нийгмийн бодит байдлыг үнэн зөвөөр боловсруулан гаргаж чадаагүй зэрэг дутагдал бий. Гэхдээ энэ бүтээл нь тухайн цаг үедээ хөндөгдөж байсан зорилт, амьдрал, түүнийг онол-арга зүйн зохих түвшинд авч үзсэн төдийгүй тухайн үеийнхээ нийгэм-улс төр, философи, социологийн сэтгэлгээний түүхийн онцлогийг бүрэн тусгаж чадсанаар судалгааны чухал баримт болсон ба одоог хүртэл үнэ цэнээ алдаагүй байна.

Бидний дараагийн дурдах бүтээл бол Монгол Улсад оршсоор ирсэн нийгэм, түүний нийгэм-улс төр, оюун санаа, бие хүн болоод түүний хүмүүжил, залуучуудын

¹⁶ Чулуунбаатар Г., Дашжамц Д. Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Уб., 2002, 62 дахь тал

асуудлуудыг судлан боловсруулах нь шинжлэх ухаан-коммунизмын онолын нэг чухал чиглэл байв. Тухайлбал, Монгол Улс дахь бие хүний төлөвшлийн асуудал, хуучин нийгэм, өнгөрсний үлдэгдэл, өнөөгийн сөрөг, харш үзэгдэл, монголын залуучуудын нийгмийн идэвхийн асуудлаар онол-арга зүй, нийгэм, улс төр, социологийн, ёс зүйн аспектэй, олон талтай судалгааг явуулсан. Үүний үр дүнд гарсан *“Өнгөрсний үлдэгдэл, өнөөгийн сөрөг үзэгдэл, түүнийг даван туулах асуудал”* (ШУА, ФСЭХ, УБ., 1988) хамтын бүтээлд социализм бол өмнөх капиталист, зарим оронд феодалын нийгмийг халсны үр дүн болж гарч ирэх шинэ нийгэм бөгөөд социализм өмнөх нийгмээс уламжлагдаж үлдэх өнгөрсний хуучирч хоцрогдсон олон янзын үзэгдэл, социализмын үед шинээр гарч ирэх олон янзын шинэ, сөрөг элдвийн харш үзэгдэл монголын нийгэмд нийтлэг буйг дурджээ. Цаашлаад өнгөрсний үлдэгдлийн гол илрэл бүхий үзэгдэл бол шашны мухар сүсэг, үндсэрхэх үзэл, хувийн өмчийн үзэл санаа, хоцрогдож хуучирсан, шинэ амьдрал, хөгжилд саад болж буй элдэв сөрөг үзэгдэл хэмээн үзсэн бол социализмын үед гарч буй элдэв сөрөг, хор холбогдолтой үзэгдлийн тоонд хүнд суртал, хэлбэрдэлт, хуурч мэхлэх явдал, шунахай хэрэглээ, хуучирсан сэтгэлгээ, арга барил, хариуцлагагүй, сахилгагүй байдал, хөдөлмөрийн бус орлого, архидан согтуурах, албан тушаал эрх мэдлийг хортойгоор ашиглах, хөрөнгөтний үзэл суртал, аж төрх ёсны гаж нөлөө түүнд автагдах явдал зэргийг багтаан үзжээ. Чингэвч, тухайн үеийн намын бодлого, үзэл суртал хийгээд нийгэм судлалд ноёрхож байсан ягшмал, догматик онол, өрөөсгөл арга зүй, судлаачдын болгоомжлол, бүтээлч бус хандлага, байр суурь, ухаалаг зоримог бус шийдэл тусгагдсан байдал ажиглагддаг.

XX зууны хориод оноос ерээд он хүртэлх хугацаанд Монгол оронд хийгдэж хэрэгжсэн нийгмийн олон талт өөрчлөлт, шинэчлэлийн бодит үр дүн, чухал ололтуудын нэг бол шинэ маягийн хүн бий болсон явдал мөн бөгөөд үүнийг үгүйсгэх аргагүй. Энэ талаар *“БНМАУ дахь социалист бие хүний төлөвшил хөгжлийн асуудал”* (ШУА, ФСЭХ, УБ., 1988) хамтын бүтээлд бие хүний судалгааны онол арга зүй, монголд шинэ бие хүн төлөвшсөн явц, бие хүний үзэл санаа-улс төрийн төлөвшил, хүмүүжил, мөн шинэ хүний хөдөлмөр, эдийн засгийн хүмүүжил, эх оронч ба интернациональч үзэл, ёс суртахуун, хамтач үзэл, сахилга хариуцлага, гоо сайхны үзэл, бие бялдрын хөгжил зэрэг шинэ бие хүний талаарх марксист ба бусад үзэл баримтлалын асуудлыг хөндсөн нь ихээхэн сонирхол татдаг. Энэхүү судалгааны үр дүнд *“Нийгмийн харилцааны төгөлдөржил ба бие хүн”* (Д.Чулуунжав, УБ., 1980) нэг сэдэвт бүтээл гарсан ба түүнд нийгэм, нийгмийн харилцаа ба бие хүний төлөвшил, хөгжил, хүмүүжил нь хоорондоо нягт холбоо хамааралтай болохыг тухайн үеийн монголын амьдралын жишээн дээр гаргаж тавьсан нь ихээхэн онцлогтой.

Энэ бүхнээс үзвэл, бидний өгүүлэн буй цаг үед шинжлэх ухааны коммунизмын онол, марксист-ленинист улс төрийн философи сэтгэлгээний онцлогийг тодорхой хүрээнд илэрхийлэх нь чухал. Шинжлэх ухааны уламжлалт бүтэц, зохион байгуулалтын бүрдэл нь үндсэндээ судалгаа, хамтын ажиллагааг хялбаршуулах, эсвэл санаатай болон санамсаргүй зорилтод чиглүүлэхэд оршино. Шинжлэх ухааны хоршсон хүрээ нь ямар нэгэн зугаа цэнгэл төдийхнөөр бус аливаад тууштай, бүтээлчээр хандаж гэмээ нь өөрийн мөрөн дээрх том саад бэрхшээлийг даван туулж чадна. Мэдээж хэрэг, агуу том амжилтыг бүтээн цогцлуулах боломжтой авч, юуны түрүүнд аливаад бүтээлчээр хандаж, хичээл зүтгэлтэй байсны эцэст түүнийхээ үр шимийг хүртэж чаддаг байх нь тэдний өөрсдийн оруулсан хувь нэмрээ дараагийн үеийн жирийн нэгэн дадлагажигчдад бэлэглэж чаддаг сэтгэлийн тэнхээтэй байхын тулд сэтгэл

зүйн хувьд бэлтгэлтэй¹⁷ байх нь чухал зүйл. Учир нь бид бүхний өвөг дээдсээс өвлөн авсан шинжлэх ухааны уламжлал нь орчин цагийн практиктай хосолж байж гэмээ нь бидний хүсэж мөрөөддөг тэрхүү ардчилсан, шударга, хүмүүнлэг энэрэнгүй нийгмийн орчныг бүрдүүлж, улмаар нэг үзэл санаанд нэгтгэгдэн нэгэн цагт хүчирхэгжүүлэх боломжийг нээж өгөх нь цаг хугацааны асуудал мөн.

Тэр утгаараа манайд улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн үеийн эхэн үе бүхэлдээ “марксист” улс төрийн ухаан буюу шинжлэх ухааны коммунизмын онолын арга зүйд суурилж байв. Тухайн үед улс төрийн нэг нам, түүний удирдагчийн санаа бодлыг бүх талаар зөвтгөж дэмжихэд чиглэгдсэн *хэт намчирхаж хэлбэрдсэн, үзэл сурталжсан, бусдыг даган дуурайсан* судалгааны онол, арга зүй ноёрхсоор байв. Хэдий тийм боловч, энэ цаг үеийн улс төр судлаачид судалгааны тэрхүү хэлбэржсэн, намжсан онол, арга зүйн хүрээнд ч Монголын нийгмийн тухайн цаг үеийн тулгамдсан суурь асуудлыг олон талаас нь аль болохоор үнэн баримттай, бодитой судлан шинжлэхийг чармайж ирснийг үгүйсгэх боломжгүй. Энэ үйл хэрэгт тухайн үеийн ФСЭХ-ийн Шинжлэх ухааны социализмын онолын секторын эрдэмтэн судлаачид гол үүрэг гүйцэтгэсэн байдаг. Тэд тухайн цаг үеийн Монголын нийгмийн амьдралын улс төрийн тулгамдсан суурь асуудал болох социалист аж төрөх ёс, нийгмийн бүтэц, социалист бие хүний төлөвшил, залуучуудын хүмүүжил, сэтгэлгээ, нийгэм дэх сөрөг үзэгдэл, түүний хор уршиг, нийгмийн ухамсрын төлөвшлийн асуудлыг дагнан судалж, олон арван суурь бүтээлийг туурвин үлдээсэн байдаг. Тухайлбал, 1986-1990 онд монголын залуучуудын нийгэмшил, хүмүүжил, нийгмийн идэвхийн асуудлыг нийгэм-улс төрийн ба социологийн аспектээр судлан боловсруулах төлөвлөгөөт ажлыг тухайн үед үүсгэсэн нь өнөөг хүртэл шинэ сэтгэлгээ, онол, арга зүй, үзэл баримтлалын шинэ эрэл хайгуулын илрэл болсон. Энэ бол “Монголын залуучуудын хүмүүжил, төлөвшил, нийгмийн идэвх” (Уб., 1991)-ийн талаар өгүүлсэн эл судалгааны хамтын бүтээлийг шинэ цаг үеийн уур амьсгалын урьдчилан таамагласан, шинэлэг зоримог сэтгэлгээгээр урьд өмнө нэг их хөндөгддөггүй байсан хурц асуудлуудыг дэвшүүлж, нэлээд шүүмжлэлт байдлаар бичсэн нь цаг үеэ олсон бүтээл байв. Нөгөөтээгүүр, 1980-иад оны сүүлчээр өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн давалгаанд Монголын нийгэм бүхэлдээ татагдан орж нэг талаас нийгмийн шинжлэх ухааны шинэлэг онол, чиглэлийн бүтээлч зоримог шүүмжлэлт сэтгэлгээ дээшилж хөгжихөд нөлөөлж буй хүчин зүйлс, нийгмийн шинэчлэлт нь нийгмийн ухааны өмнө цоо шинэ зорилт, хурц асуудлуудыг¹⁸ дэвшүүлэн тавьснаараа онцлогтой. Энэ бол монгол оронд байгуулсан нийгэм чухам мөн чанараараа социалист нийгэм бус, ихээхэн гажуудсан, ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, зах зээлийг боож хаасан тоталитар нийгэм байсан гэдгийг хүлээн зөвшөөрснөөр шинжлэх ухаан коммунизмын онол нийгэм дэх статусаа алдаж, улмаар түүний онол, арга зүй, танин мэдэхүй, судалгаа шинжилгээ нь хямралд орж, шинжлэх ухааны тавцангаас шахагдахад энэ мэтчилэн олон янзын нөхцөл байдал, хүчин зүйлс шалтгаалсан. Тухайлбал, тоталитар төр, эрх баригч нам байгууллага түүний догматик үзэл суртал, улс төрийн бодлогын хатуу хараа хяналтад орж, цаашлаад шинжлэх ухааны бүтээлч, шүүмжлэлт шинж чанар алдагдаж, үнэн хэрэгтээ бусармаг үзэл суртал болж хувирсанд түүний эмгэнэлт байдал оршино. Тиймээс өдгөө тэрхүү бүтээл туурвилын үр дүнг авах гээхийн ухаанаар шүүн тунгааж, алдсаныг нь засаж залруулан, оносныг нь бүтээлчээр авч ашиглах нь эрдэм судлалын ажлын залгамж чанарын шинэлэг үргэлжлэл, шинжлэх

¹⁷ ФСЭХ, ШУА. “Философи эрхийн судлал- XXIII”. Эрдэм шинжилгээний цуврал. Уб., 2008. 300, 301 дэх талууд

¹⁸ Чулуунбаатар Г., Дашжамц Д. Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Уб., 2002, 68 дахь тал

ухааны ёс зүй, уламжлалын жам ёс мөн билээ.

Түүхэн баримтаас үзвэл, МАХН-ын XVII их хурал нийгмийн шинжлэх ухааны энэ цаг үеийн судалгааны чиглэл, агуулга, зорилтыг тодорхойлохдоо “...манай орны байгалийн нөөц баялгийг хамгаалах, үр бүтээлтэй ашиглах, үйлдвэрлэх хүчийг хөгжүүлэх, социалист үйлдвэрлэлийн харилцааг боловсронгуй болгох, цаашлаад улс ардын аж ахуй, соёлын янз бүрийн салбарыг хөгжүүлэх гол зангилаа асуудлыг судлан шинжилж, боловсруулахад бүх анхаарал, эрдэм шинжилгээний хүчээ төвлөрүүлэх чухал зорилт тулгарч буйг дэвшүүлсэн байна. Мөн социалист байгуулалтын онол-практикийн нэн чухал асуудлуудыг гүнзгий судлах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийг төлөвлөх, удирдах ажлыг улам боловсронгуй болгох, түүнчлэн шинжлэх ухаан-техникийн дэвшлийн ололтыг улс ардын аж ахуйд нэвтрүүлэх, хөдөлмөрчдийн ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэх. Зөвлөлт Холбоот Улс болон ах дүү социалист бусад орнуудтай бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг гүнзгий судлахыг манай шинжлэх ухааны ажилтан нараас нам хүлээж байна”¹⁹ гэж заажээ. Энэхүү заалттай уялдуулан олон арван судалгааны өгүүлүүдийг хэвлүүлсэн байдаг. Тэдний заримаас нь жишээ болгон ишлэхэд дараах сонирхолтой дүр зураг ажиглагдсан нь өнөөгийн судлаачдад онолын хийгээд практик ач холбогдол буйг харуулна. Тухайлбал, судлаач С.Ядам²⁰ “...Социалист ардчилал бол хөдөлмөрчдөд нийгэм-улс төрийн эрх, чөлөөг хангаж, тэднийг үйлдвэрлэлийг удирдахад оролцуулах хамгийн үр ашигтай хэрэгсэл мөн. Иймээс үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг улам бүр ардчилсан ёсоор хөтлөн зохион байгуулах үйлсэд үлэмжхэн хүчтэй хэрэгсэл болох социалист уралдааны асуудлыг судалж, түүнийг улам боловсронгуй болгох нь онол практикийн чухал ач холбогдолтой юм...” хэмээн үзжээ. Харин судлаач Д.Чулуунжав²¹ “...үйлдвэрлэлийн удирдлагыг өөртөө багтаадаг төлөвлөгөөт зохион байгуулалт бол социалист үйлдвэрлэлийн харилцааны онцлог шинж юм. Социализмын үед үйлдвэрлэлийн процессын төлөвлөгөөт зохион байгуулалт нийгмийн үйлдвэрлэлийг бүхэлд нь хамарч, үйлдвэрлэлийг түүхэнд анх удаа нийт нийгмийн хэмжээнд, нийт нийгмийн эрх ашгийн үүднээс нэг төвөөс удирдах бололцоо олгодог”²² хэмээн өөрийн хэд хэдэн өгүүлэлдээ онцолсон байх жишээтэй. Тэгвэл профессор С.Норовсамбуу МАХН-ын XVIII их хурлын талаар “МАХН-ын XVIII их хурал ба социализмын онолын зарим асуудал”²³ эрдэм шинжилгээний өгүүлэлдээ “...орчин үеийн шинжлэх ухаан, техникийн дэвшлийн ололтыг үндэс болгож социалист нийгмийн үйлдвэрлэх хүчнийг бүхий л талаар хөгжүүлэх, нийгмийн социалист харилцааг боловсронгуй болгох, социалист соёлыг түргэн хурдацтай өрнүүлэх, хөдөлмөрчдийг коммунист ёсоор хүмүүжүүлэх ажлыг хүчтэй болгох, улмаар ард түмний аж амьдралын байдал, соёлын хэмжээг цаашид дээшлүүлэх явдал мөн” хэмээн социализм байгуулж дуусгах үеийн үндсэн агуулгыг тодорхойлох санааг дэвшүүлсэн нь үнэхээр сонирхол татахуйц дүр зураг байлаа.

Энэ бүхнээс дүгнэвэл, өгүүлэн буй үеийн эрдэмтэн судлаачид нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг нарийвчлан судалж, нэгтгэн дүгнэж, улмаар тус орны хөгжлийн

¹⁹ Цэдэнбал Ю. Монгол Ардын Хувьсгалт Намын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл. Уб., 1976. 54-55 дахь тал

²⁰ Ядам С. “Социалист уралдаан үйлдвэрлэл дэх ардчиллын хэлбэр болох нь”. Философи эрхийн судлал-II. ФСЭХ, ШУА. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1980. 145 дахь тал

²¹ Чулуунжав Д. “Социализмын үйлдвэрлэлийн харилцааны онцлогийн асуудал”. Философи, эрхийн судлал-III. ФСЭХ, ШУА. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1980. 55 дахь тал

²² ФСЭХ, ШУА. Философи, эрхийн судлал-III. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1980. 60 дахь тал

²³ ФСЭХ, ШУА. Философи, эрхийн судлал-IV. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1982

онол, практикийн асуудлыг судлан боловсруулахад гол анхаарлаа хандуулж байсан нь илэрхий. Чингэхдээ БНМАУ-ын капиталист бус хөгжлийн зам болон социалист байгуулалтын онолын зарим асуудлыг судлах, нийгмийн социалист харилцааг хөгжүүлэн боловсронгуй болгох, хөдөлмөрчдийн коммунист хүмүүжил, социалист аж төрөх ёсыг хэвшүүлэн тогтоох онол, практикийн асуудлуудыг судлан боловсруулж байжээ. Нөгөө талаас, судалгааны ажлыг зохион байгуулахад судлаачдын эгнээг өргөтгөх, мэдлэг боловсрол, ур чадварыг нь дээшлүүлэх асуудал чухлаар тавигдсаар иржээ. Үүний тод жишээ бол, судлаачдын онол, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар МАХН-ын XVII их хурлын нэгэн илтгэлд *“...эрдэм шинжилгээний ажлын онолын хэмжээ, эдийн засгийн өгөөжийг дээшлүүлэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийг нягт холбоотой болгох, эрдэм шинжилгээний боловсон хүчний бэлтгэлийг сайжруулах, тэдэнд үзэл суртал-улс төрийн хатуужил суулгах, байгаль болон нийгмийн үзэгдлийг задлан шинжлэхэд эрдэм шинжилгээний ажилтан нарыг марксист-ленинист аргаар зэвсэглэх явдал эрдэм шинжилгээний газрын удирдлага, тэдгээрийн дэргэдэх намын байгууллагын анхаарлын төвд ямагт байх ёстой”*²⁴ хэмээн тодорхой тусгасан байна. Энэ нь хэдийгээр марксист-ленинист үзэл суртлыг нийгэмд тулгаж байсан ч судалгаа шинжилгээний үр дүнг нийгэмд түгээж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарч байсны илрэл мөн.

Энэхүү үйл явцад тухайн үеийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын болон их сургуулийн энэ чиглэлийн судалгааг дагнан хийдэг судлаачид ч манлайлан оролцож, онол-практикийн чухал санал, санаачилгуудыг өрнүүлж байсан түүхийг мартах ёсгүй. Ийнхүү дурдсан өрнөлт нь угтаа хамгийн бага түвшинг маш өргөн хүрээнд хүртээж чадаж гэмээ нь туйлын хүсэл тэмүүллийг бий болгож түүнийг хувьсган өөрчлөх их оролдлого байв. Өөрөөр хэлбэл, *“энгийн үндэслэл”*-ээс нийтлэг хэлцлийг нэмэгдүүлснээр улс төрийн шинжлэх ухааны мэргэжил дэх *“мэргэжлийн хамгийн энгийн чадвар”*-аар тодорхойлогддог онцлог гэж болно. Тиймээс, улс төрийн шинжлэх ухаанд эрүүлжих явдал хамгаас чухал байдаг бөгөөд түүнийгээ өөрийн хүрээний дэд онцлог шинж бүрд хамруулж, цаашлаад дотоод давуу талаа ашиглан улс төрийн фракцын гишүүн бүртэй ойлголцож, тэдэнд тодорхой хэмжээнд хариуцлага тооцон ажиллах нэн чухал. Тэрхүү *“эрүүлжүүлэх”* амин дэм нь их өргөн утгатай, хоорондоо харилцан холбоотой дэд онцлогуудаас бүрдсэн утгын нарийн шүтэлцээ бүхий том цогц зүйл байх учиртай.

Ийнхүү 1990-ээд оноос өмнө хийгдэж байсан улс төрийн түүхийн судалгааны хүрээнд түүхэн бие хүмүүсийн намтар судлал нь түүний нэгэн чиглэл болон тавигдаж түүгээр XX зууны эхэн үе, ялангуяа 1921 оны ардын хувьсгал ба түүний дараах нийгмийн хувьсгалт өөрчлөлтийн үйл хэрэгт хүчин зүтгэж байсан монголын төр, нам, цэргийн томоохон зүтгэлтэн бүхий түүхэн бие хүмүүс, нэг ёсны лидерүүдийн амьдрал, нийгэм-улс төр, цэргийн үйл ажиллагааг судлан илэрхийлэгдэж байв. Түүнчлэн 1990-ээд оноос өмнөх үед түүх, философи, төр, эрх зүйн асуудал, зарим тохиолдолд монголын уран зохиол судлалаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын дотроос монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, түүний үр дүнд гарсан ном бүтээлүүд өнөөгийн улс төрийн шинжлэх ухаанд шууд учир холбогдолтой, ихээхэн ач тустай байгааг онцлон тэмдэглэвэл зүйтэй. Учир ахул, улс төрийн сэтгэлгээ, сургаалын түүх бол улс төрийн шинжлэх ухааны бүтцэд чухал байр суурь эзэлдэг, түүний үзэл санааны түүхийг бүрдүүлдэгээрээ онцлогтой.

²⁴ Цэдэнбал Ю. Монгол Ардын Хувьсгалт Намын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл. Уб, 1976. 55 дахь тал

Нөгөө талаар, 1990-ээд он хүртэлх үед манайд хийгдэж байсан улс төрийн аспектээр судалгаа боловсруулалтын хүрээн дотор улс төрийн ерөнхий мэдлэг бүрдүүлж бий болгох, түүнийг холбогдох сурах бичиг, гарын авлага, сэдэвчилсэн эмхэтгэл, толь бичиг, лавлах материал зэрэг хэлбэрээр эмхлэн системчилж их, дээд, тусгай, дунд болон техник-мэргэжлийн сургуулиудын оюутан, суралцагчид, нам, үйлдвэрчний болон залуучуудын эвлэлийн улс төрийн сургуульд зориулан нийтэлж, хэвлэн гаргаж байсныг энд дурдвал зохино.

Эцэст нь хэлэхэд, XX зууны 20-иос 90-ээд оны эхэн үед төр, нам, улс төрийн бусад үзэгдэл, үйл явдлын асуудлаар хийгдсэн улс төрийн судалгаа, түүний үр дүнд нийтлэгдсэн ном зохиол, бусад бүтээл, хуримтлагдсан туршлага, баримт материал, мэдээллийн бааз, дурдсан чиглэлээр судалгаа хийж, мөн их, дээд сургуульд хичээл зааж бэлтгэгдсэн эрдэмтэн судлаачид багагүй хүч нөөцийг бүрдүүлж байсныг үгүйсгэх аргагүй. Чухамхүү эл оюуны хүч нөөц нь 1990-ээд оноос манай оронд орчин цагийн улс төрийн шинжлэх ухааны үндэс суурь тавигдаж, цааш төлөвших хөгжих эхлэл, суурь хөрс нь болоход чухал хувь нэмэр оруулсныг онцлох хэрэгтэй. Нэг үгээр хэлбэл, Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийн тухай яриа нэлээд эртнээс яригдах учиртай²⁵ бөгөөд манай оронд улс төрийн шинжлэх ухаан огт хоосон газар гэнэт бий болсон биш гэдгийг энд зориуд тэмдэглэхийг бид зорив. Нөгөөтээгүүр, эл шинжлэх ухаан өөрийн онол, арга зүй, зарчим, бүтэц, зохион байгуулалт, судалгааны арга техникээрээ бие даасан шинжлэх ухаан болохын хувьд бидэнд шинэ зүйл байсныг мартах учиргүй. Өөрөөр хэлбэл 1990-ээд оноос өмнөх улс төрийн судалгаа нь онол-танин мэдэхүй, нийтлэгдсэн ном зохиол, мэдээллийн бааз, багтаамжийн хувьд хэдийгээр чухал ач холбогдолтой, үнэ цэнтэй ч гэсэн өөрийн мөн чанар, шинжлэх ухааны статусаараа өрнийн орнуудад хөгжиж ирсэн улс төрийн шинжлэх ухаантай ижил төстэй биш, зарчмын чанартай олон зүйл бүхий үзүүлэлтүүдээрээ ялгаатай өөр судалгаа байв. Тиймээс ч түүнийг тогтолцоогоор нь халж, өөрчлөх, чингэхдээ өмнөх үеийнхний өвлүүлэн үлдээсэн үндэсний онцлог бүхий үнэ цэнтэй ололт, амжилт, нөөц хүчийг нь зүй зохистой хадгалах, өөрчлөх, ашиглах замаар өрнийн нэгэнт тогтож төлөвшсөн улс төрийн шинжлэх ухааныг шинээр нутагшуулан цогцлоох, төлөвшүүлэн хөгжүүлэх чухал бөгөөд бэрхшээлтэй зорилт зайлшгүй тавигдсан билээ. Энэ талаар дараагийн хэсэгт тухайлан авч үзэх болно.

²⁵ Ганболд Ц. Монголын их дээд сургуулиудад улс төр судлалын хичээлийг зааж буй байдал. Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин. ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. ред. Ганбат Д. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 42 дахь тал